

СОЛОНГОС УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ХАМТРАН ӨМЧЛӨХ ДУНДЫН ӨМЧИД ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ОРЛОГО ХАМААРНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2014716선고 2012므2888

Шүүхийн шийдвэрийн огноо: 2014оны 07 дүгээр сарын 16-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

А, Б нар 1993 онд гэрлэж, 2008 оноос тусдаа амьдарч эхэлсэн. Гэрлэгсдийн хамтын амьдралын хугацаанд эхнэр болох А нь ар гэрийн ажлыг голчлон хариуцаж харин нөхөр болох Б нь 1977 оноос цагдаагийн албан хаагчаар ажиллан, 2006 онд төрийн албаны өндөр насны тэтгэвэрт гарч, сар бүр 2,128,600 воны тэтгэвэр авахаар тогтжээ. А, Б нар 2012 онд гэрлэлтээ цуцлуулах болж, эхнэр А гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болох хариуцагч Б-ийн төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэврээс өөрт ноогдох хувийг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан байна.

Хариуцагч Б дээрх нэхэмжлэлийн шаардлагуудаас гэрлэлт цуцлуулах шаардлагыг нь зөвшөөрч харин гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө гэж үзэж буй төрийн албан хаагчийн өндөр настны тэтгэврээс ногдох хувийг гаргуулах хэсгийг эс зөвшөөрч маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 839.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч нь хариуцагчаас төрийн албан хаагчийн тэтгэврээс ноогдох хувийг хуваах тухай нэхэмжлэлийг хангахгүйгээр шийдвэрлэжээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
<https://www.law.go.kr/LSW/precInfoP.do?precSeq=187485>

Ингэхдээ, тус хуулийн 839 дүгээр зүйлийн 839.2² дахь хэсэгт “Гэрлэлт цуцалсан буюу гэрлэлтийг хүчингүйд тооцсоноос гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, нас, гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болгоход оруулсан түүний хөдөлмөрийн оролцоог харгалзан шүүх өөрөөр тогтоож болно” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, **нэхэмжлэгч нь хариуцагчтай гэр бүлийн асуудлаа шийдвэрлэх хүчин чармайлт гаргаагүй, хариуцагчтай маргалдах явцдаа хариуцагчийн эрүүл мэндэд хохирол учруулсан үйл баримт тогтоогдсон.** Тиймээс тус хуулийн шаардлагыг хангаагүй учир эд хөрөнгө хуваах тухай нэхэмжлэлийг хангахгүйгээр шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс: Гэрлэгсдийн дундын хөрөнгийг хуваахдаа хэт нэг талыг баримталсан дүгнэлт хийсэн. Өөрөөр хэлбэл, **гэрлэгчид гэрлээд 15 жил хамт амьдарсан бөгөөд гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болгоход оруулсан нэхэмжлэгчийн хөдөлмөрийн оролцоо зэрэг үйл баримтаас үзэхэд хариуцагчтай тэнцүү хувь нэмэр оруулсан гэж үзэхээр байна.** Иймээс Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т³ заасны дагуу тэтгэврийн орлого нь гэрлэгчдийн дундын эд хөрөнгө гэж дүгнэх нь зүйтэй байна. Мөн Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт заасны дагуу хариуцагчаас төрийн албан хаагчийн сарын тэтгэврийн 30 хувьтай тэнцэх хэмжээний воныг шүүхийн эцсийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн хариуцагч нас барахын өмнөх өдөр хүртэлх хугацаанд сар бүрийн эцэст гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс: Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар **эд хөрөнгийн хуваах хувь хэмжээ нь хувийн өмчид оруулсан хувь нэмрийг хэлдэггүй, бусад бүх нөхцөл байдлыг харгалзан эхнэр, нөхрөөс бүхэлд нь бүрдсэн эд хөрөнгийн эзлэх хувийг хэлдэг.** Ингэхдээ төрийн албан хаагчийн тэтгэврийг гэрлэгчдийн дундын өмчид хуваахдаа нийт хамтран амьдарсан хугацаа болон хамтын хөдөлмөрийн хувь нэмэр болох гэрийн ажил, хүүхэд асран хүмүүжүүлэх гэх бусад бүх нөхцөл байдлыг тооцож тогтооно гэж заасан байдаг. **Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд хариуцагч төрийн албанд ажилсан хугацаа нийт 29 жил, үүнээс нэхэмжлэгчтэй гэрлэсэн хугацаа 15 жил байх тул гэрлэсэн хугацаа нь хариуцагчийн ажилласан хугацааны 40 орчим хувийг эзэлж байгаа нь харагдаж байна.**

Дээрх үндэслэлээр төрийн албан хаагчийн тэтгэврийн 30 хувийг нэхэмжлэгч А-д олгох нь Төрийн албан хаагчийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т болон Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт нийцсэн гэж үзэж давж заалдах

² Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 2 дахь заалт. *Өмнөх заалтад заасан эд хөрөнгө хуваах дээр харилцан тохирч чадаагүй бол гэр бүлийн шүүхээс холбогдогч этгээдийн шаардлагаар хамтын эд хөрөнгийг эд хөрөнгийн хэмжээ ба бусад шалтгааныг үндэслэн хуваах аргыг тооцно.*

³ Төрийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 3 дэх заалт. *Дээрх тэнцүү хуваах заалтыг үл харгалзан Иргэний хуулийн 839.2 , 843 дугаар зүйлд заасны дагуу тэтгэврийн хуваарилалтыг тусад нь тогтоож болно.*

шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

---oOo---